



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/254

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.1 дэх зорилт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдсан аймгийн Засаг даргын нэрэмжит анги нийтийн олимпиадын зохион байгуулалтын зардалд хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах 37,877,840 (гучин долоон сая найман зуун мянга найман зуун дөч) төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

